



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 09-ны өдөр

Дугаар А/132

Эрдэнэт

Г Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8., 8.1.3, Улсын онцгой комиссын 2020 оын 11-р сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоол, Коронавирус (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчидан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ

1. Коронавирус (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавруудын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай зөв зохион байгуулах, сэжигтэй тохиолдлыг тусгаарлах өрөөг бүсчлэх, нэг удаагийн хамгаалах хэрэгслийг бэлтгэж тавих, эрчимт эмчилгээний өрөөний бэлэн байдлыг ханган ажиллахыг Эрүүл мэндийн багууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

2. Эрүүл мэндийн байгууллагууд Коронавирус (КОВИД-19)-ын цар тахлын төлөвлөгөөг тодотгох, хэрэгжилтэнд анхаарах, хүний нөөцийн төлөвлөлтийг нарийвчлан гаргаж, дайчлан ажиллах зохион байгуулалтыг хийх, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, эм, тарианы нөөцийг нэмэгдүүлэх, дохиолол мэдээллийн системийг ажиллуулах, эрүүл мэндийн байгууллагуудын камерийн хяналтыг сайжруулж халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн өндөр сонор сэрэмжтэй байж, угтуулсан сэргийлэлт хийж ажиллахыг бүх шатны Эрүүл мэндийн багууллагуудын дарга нарт даалгасугай.

3. Ковид-19-ийг эмчлэх тасгуудын бэлэн байдлыг хангуулж, шаардлагатай багаж тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, ажиллах хүний нөөцийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах хүрээнд ХӨСҮТ, Сэлэнгэ аймгуудтай цахимаар холбогдох, эмчилгээ үйлчилгээний дадлага сургуулилт тогтмол хийж чадавхжуулах, эмнэлэгт хэвтэж байгаа болон ялангуяа амсгалын замын цочмог хам шинжээр өвчилж ирсэн хүн нэг бүрт түргэвчилсэн тестийг тавьж тандалт судалгааг хийж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга /Б.Батсүх/- д даалгасугай.

4. Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэхдээ холбогдох шатлалын эмнэлэгтэй урьдчилан мэдэгдэж, өвчтөнийг хүлээн авахыг зөвшөөрсөн үед өвчтөнийг халдвараас сэргийлэх хяналтыг баримтлан тээвэрлэхийг хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Бага насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн, эмэгтэй, төрсөн эх, хэвтрийн өвчтэй иргэнд тавих хяналтыг сайжруулж цахимаар болон утсаар тогтмол биеийн байдлыг хянах, зөвлөгөө өгч ажиллахыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

6. Эрүүл мэндийн ажилтнуудын дархлааг сайжруулах, сэлгэн ажиллуулах, ажлын ачааллаас үүдэлтэй харьцаа хандлага ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцож ажиллахыг Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/, Эх хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /П.Хишгээ/, Хяналт шинжилгээ үнэлгээний дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/ нарт тус тус даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ